



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24

Дугаар 24/02

Хэрлэн сум

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Адуунчулуун” хувьцаат компанийн 2023 оны тайлангаар алдагдалтай гарсан тул Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ШИЖИР



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 24

Дугаар 24/03

Хэрлэн сум

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны
үйл ажиллагааны тайлан
батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Адуунчулуун” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ШИЖИР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24

Дугаар 24/04

Хэрлэн сум

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны цалин урамшуулал, зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ШИЖИР

"Адуунчулуун" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
Ээлжит бус хурлын 2024 оны 07 дүгээр сарын 24-ний
өдрийн 24/04 тоот тогтоолын хавсралт



"Адуунчулуун" ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв

д/д	Зардлын төрөл	Нийт зардал /төг/
Цалин, урамшууллын зардал		
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	69,014,400
2	НДШ	9,351,888
	Дүн	78,366,288
Бусад зардал		
1	Сэлбэг	1,613,872
2	Бензин	2,650,000
3	Дизель түлш	300,000
4	Шатах тослох материал	400,000
5	Шуудан холбоо	1,000,000
6	Сургалт	450,000
7	Бичиг хэрэг	50,000
8	Бусад зардал	560,000
	Дүн	7,023,872
	Нийт дүн	85,390,160



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 24

Дугаар 24/05

Хэрлэн сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, компанийн дүрмийн 7.8.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ** нь:

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

- | | |
|-------------------------------|---------------------------|
| - Цошгтсайхан овогтой Шижир | /1608850 кумулятив санал/ |
| - Шатар овогтой Баясгалан | /1608850 кумулятив санал/ |
| - Баттогтох овогтой Батсайхан | /1608850 кумулятив санал/ |
| - Шатар овогтой Идэр | /1608850 кумулятив санал/ |
| - Санжаа овогтой Бадарч | /1608850 кумулятив санал/ |
| - Лханаажав овогтой Батмөнх | /1608850 кумулятив санал/ |

Хоёр. Хараат бус гишүүнд

- | | |
|---------------------------------|---------------------------|
| Баярсайхан овогтой Ганхуяг | /1608850 кумулятив санал/ |
| - Баяндэлгэр овогтой Энхбаатар | /1608850 кумулятив санал/ |
| - Сугаржав овогтой Номин-Эрдэнэ | /1608850 кумулятив санал/ |

нарыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 1 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ШИЖИР